

БАТЛАВ. ХАВДАР СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.ЭРДЭНЭХҮҮ

БАТЛАВ. "ХАВРЫН БЭЛЭГ"
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Б.БОЛОРТУЯА

**КОВИД-ЫН ҮЕД БЭЛЭН БАЙДЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ
ХУВАНЦАР БАРАА НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Дугаар: ЭХНХАГ-2021/02

Улаанбаатар хот


Нэг талаас **Хавдар судлалын үндэсний төв** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас "**ХАВРЫН БЭЛЭГ**" ХХК (цаашид "нийлүүлэгч" гэх) нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **КОВИД-ЫН ҮЕД БЭЛЭН БАЙДЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ХУВАНЦАР БАРААГ** (цаашид "бараа" гэх) **5,269,000 / таван сая хоёр зуун жаран есөн мянга /** төгрөгийн **бараа** (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг **5,269,000 / таван сая хоёр зуун жаран есөн мянга/** төгрөгийг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь **13** нэр төрлийн барааг **2021** оны **01** дүгээр сарын **13**-ны өдрөөс **2021** оны **01** дүгээр сарын **23**-ны өдрийн дотор нийлүүлж, хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
 1. Гэрээний ерөнхий нөхцөл;
 2. Гэрээний тусгай нөхцөл;
 3. Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
 4. Санхүүжилтийн хуваарь
6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.
9. Төлбөрийн нөхцөл: Захиалагч нь чанарын шаардлага хангасан барааг хүлээн авсны дараа тооцоог дүгнэж төлбөрийг гүйцэтгэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


Байгууламжийн менежмент,
Аюулгүй байдлын албаны дарга
Ц.Энхсаруул

.....


Санхүү, бүртгэлийн албаны
дарга Ц.Энхээ

.....


Дотоод аудитор Х.Гансүх

.....


Хаяг:

Хавдар судлалын үндэсний төв
БЗД-ийн 18-р хороо. Намянжүгийн
гудамж. Баянзүрх дүүрэг.

Утас: 450043,

Факс: 976-11-458189

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ХАВРЫН БЭЛЭГ" ХХК-ийн
захирал
Б.Болортуяа



Хаяг:

"ХАВРЫН БЭЛЭГ" ХХК ХАН УУЛ
дүүрэг 1-р хороо 37-31 тоот

Утас: 99017690

Факс:

Регистр: 6375081

Данс: ГОЛОМТ банк - 1415124363